ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний сэлбэг хэрэгсэл,

стандарт бус ган хийц үйлдвэрлэх ажил

1. ЗАХИАЛАГЧ: Баяжуулах үйлдвэр (БҮ):
2. АЖЛЫН АГУУЛГА:

Тасралтгүй үйл ажиллагаатай Баяжуулах үйлдвэрийн нөөцгүй ажилладаг технологийн тоног төхөөрөмжүүдэд шаардлагатай стандарт бус металл ган хийцийг техникийн зураг, захиалгын дагуу хийж гүйцэтгэх, актаар хүлээлцэх.

3. ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ХЭМЖЭЭ:

Металл ган хийцийн нийт жин, Бүгд 300 тонн. Үүнд:

3.1. БАГЦ-1: БҮ-ийн Нунтаглан баяжуулах хэсэг (НБХ)-ийн стандарт бус металл хийцийн үйлдвэрлэл, Нийт жин–100 тонн.

3.2. БАГЦ-2: БҮ-ийн Бутлах тээвэрлэх хэсэг (БТХ)-ийн стандарт бус металл хийцийн үйлдвэрлэл, Нийт жин-100 тонн.

3.3. БАГЦ-3: БҮ-ийн Өөрөө нунтаглах хэсэг (ӨНХ)-ийн стандарт бус металл хийцийн үйлдвэрлэл, Нийт жин–100 тонн.

4. АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ НЬ ДАРААХ ШААРДЛАГУУДЫГ ХАНГАСАН БАЙХ:

4.1. Сүүлийн 3 жилд төрийн өмчит үйлдвэрийн газруудад металл хийцийн ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх.

4.2. Ажил гүйцэтгэгч компани нь техникийн зураг унших мэдлэгтэй, мэргэжлийн боловсон хүчинтэй байх. (Ажилтнуудын мэргэжлийн үнэмлэх, диплом, сертификатыг хавсарган ирүүлэх).

4.3. Металл хийц үйлдвэрлэлийн өөрийн цех, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй байх. Үүнд:

- Металл хийцийн ажил гүйцэтгэх ган хоолой матагч, хуудсан төмөр хуйлах, нугалах, огтлох, зүсэх, өнгөлгөөний машин, суурин таслагч, гар таль, өргөх

төхөөрөмж, токарь, фрезерийн суурь машин, төрөл бүрийн гагнуурын аппарат, оосорлох хэрэгслүүд бусад туслах тоног төхөөрөмжүүдтэй байх. (Цехийн үйл ажиллагааны талаарх товч танилцуулга ирүүлэх, үндсэн хөрөнгийн гэрчилгээтэй эзэмшигч байх, нотлох баримт ирүүлэх).

- Ажил гүйцэтгэгч компани нь төмөрлөг боловсруулах, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх. (Ажил эхэлснээс хүлээлгэн өгөх хугацаанд хүчин төгөлдөр байх).
- Металл хийцийг үйлдвэрийн нутаг дэвсгэрт тээвэрлэн хүргэх, буулгах тээврийн хэрэгсэлтэй байх. (20 тн-с дээш даацтай).

5. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, АЖИЛБАРУУД:

5.1. 2026 оны 11 дүгээр сарын 01-ний дотор үйлдвэрлэж, ажлын байранд нь хүргэж, хүлээлгэн өгнө. (Баталгаажуулсан гэрээний хугацаа: Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 2029 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл байна).

5.2. Баталгаажсан гэрээг үндэслэн захиалагч цехийн техникийн даалгавар, техникийн зургаар төлөвлөгдсөн Их-зогсолтын ажил, Их-засварын ажил, Үндсэн технологийн хэсгүүдийн шугамын урсгал засварын ажил, Өргөтгөл шинэчлэлийн ажилд шаардлагатай стандарт бус ган хийцүүдийг үйлдвэрлэх.